



Орхон аймгийн Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлж буй иргэдээс авсан 2024 оны 10 дугаар сарын Сэтгэл ханамжийн судалгааны нэгтгэл

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО: Энэхүү судалгаа нь Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйлчилгээг сайжруулах, иргэдийн сэтгэл ханамжийн дээшлүүлэхэд оршино.

СЭТГЭЛ ХАНАМЖ: Сэтгэл ханамж гэдэг нь хэрэглэгч /нийгмийн даатгалын үйлчилгээ авч буй иргэд/ Нийгмийн даатгалын үйлчилгээнээс гарч буй чанарын түвшин буюу тухайн үйлчилгээг хэрхэн үнэлж байгааг илтгэдэг бөгөөд үр дүн нь тоон хэмжүүрт тулгуурласан байдаг.

АЧ ХОЛБОГДОЛ: Хэрэглэгчийн тухайн Нийгмийн даатгалын байгууллагын үйлчилгээнээс буй хүлээлт хүссэн үйлчилгээг нь үр дүнтэй болгох.

СУДАЛГААНЫ АРГА АРГАЧЛАЛ: Санал асуулгын түүвэр судалгааны аргыг ашиглан SPSS программ дээр шинжилнэ.

СУДАЛГААНЫ БАРИМТЛАХ ЗАРЧИМ

- Судалгааны үр дүн нь ач холбогдолтой, үйл ажиллагаанд шууд авч ашиглах боломжтой байх.
- Хөндлөнгийн хараат бус байх
- Шинжлэх ухааны үндэслэлтэй, мэргэжлийн аргачлал арга зүйг судалгааны бүхий л үе шатанд дагаж мөрдөх

МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ: Орхон аймгийн Нийгмийн даатгалын газрын үйлчилгээний А заал 101 тоотоос иргэдээс нээлттэй байдлаар санал асуулга авсан.



СУДАЛГААНЫ АСУУЛГУУД

Зураг-1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн хүйс:



Дүгнэлт: Орхон аймгийн Нийгмийн даатгалын газраар үйлчлүүлэхээр ирсэн иргэдээс сэтгэл ханамжийн судалгаанд 57 иргэн хамрагдсан байна. Судалгаанд хамрагдсан иргэдийг хүйсээр авч үзвэл 41 иргэн буюу 71.9% эмэгтэй, 16 иргэн буюу 28.1% нь эрэгтэй гэсэн тоон үзүүлэлт гарч байна.


Зураг-2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн насны ангилал:



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн насны хувьд авч үзвэл 20-29 насны 10 иргэн буюу 17.5%, 30-39 насны 21 иргэн буюу 36.8%, 40-49 насны 14 иргэн буюу 24.6%, 50-59 насны 11 иргэн буюу 19.3%, 60-аас дээш насны 1 иргэн буюу 1.8% гэсэн тус бүрийн тоон үзүүлэлтүүд гарсан байна.



График-1: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээний төрөл:



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 57 иргэдийн тэтгэвэртэй холбоотой үйлчилгээг 14 иргэн буюу 24.6%, тэтгэмж 12 иргэн буюу 21.1%, сайн дурын даатгал 15 иргэн буюу 26.4%, нийгмийн даатгалын шимтгэл төлөлт 4 иргэн буюу 7.0%, зөвлөгөө мэдээлэл 7 иргэн буюу 12.3%, бусад 5 иргэн буюу 8.8% тус бүр авсан байна.

Зураг-3: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн үйлчилгээ шуурхай, хялбар:

Үйлчилгээ шуурхай,
хялбар байсан уу?






Дүгнэлт: Судалгаанд оролцсон 57 иргэдийн 43 даатгуулагч маш сайн үнэлгээ буюу 75.4%, сайн үнэлгээг 13 даатгуулагч буюу 22.8%, дунд үнэлгээг 1 даатгуулагч буюу 1.8%, муу, маш муу үнэлгээг өгөөгүй байна.

Зураг-4: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээллээ бүрэн авсан байдал:



Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн “Тийм” гэсэн үнэлгээг 57 иргэн буюу 100%, өгсөн байна.

График-2: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн зөвлөгөө, ажилтны харилцаа, хандлага үнэлгээ:





Дүгнэлт: Судалгаанд оролцсон иргэдийн сэтгэл ханамжтай 55 иргэн буюу (96.5%) сэтгэл дундуур 2 иргэн (3.5%) тус бүр өгсөн байна.

График-3: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн мэдээлэл ил тод байдал (Төлөвлөгөө, тайлан, хүний нөөц, худалдан авах ажиллагаа):



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 57 иргэдийн “Тийм” үнэлгээг 35 иргэн буюу (61.4%), “Үгүй” үнэлгээг 3 иргэн буюу (5.3%), “Мэдэхгүй” үнэлгээг 19 иргэн буюу (33.3%) тус бүр үнэлсэн байна.


Зураг-5: Түүвэр судалгаанд оролцсон иргэдийн ойр дотны хамаатан садан, найз нөхөд ажилладаг бол түүгээр дамжуулан үйлчилгээ авсан уу?





Дүгнэлт: Судалгаанд оролцсон 57 иргэдийн “Тийм” үнэлгээг 5 иргэн буюу 8.8%, “Үгүй” үнэлгээг 52 иргэн буюу 91.2%-тай тус бүр үнэлсэн байна.

Зураг-6: Түүвэр судалгаанд оролцсон иргэд үйлчилгээ авахдаа нэмэлт төлбөр, шууд болон шууд бус бэлэг өгөх, хандив туслалцаа үзүүлж байсан уу?



Дүгнэлт: Судалгаанд оролцсон 57 иргэнээс “Тийм” үнэлгээг 3 иргэн буюу (5.3%), “Үгүй” үнэлгээг 54 иргэн буюу (94.7%) үнэлсэн байна.

8.Та төрийн байгууллагын авлигыг бууруулах, урьдчилан сэргийлэхийн тулд юу хийх хэрэгтэй гэж үзэж байна вэ?

Нийт 6 иргэн санал, хүсэлтээ илэрхийлсэн байна.

1. Авилга өгөхгүй байх.Төрийн үйлчилгээг түргэн шуурхай танил талаар үйлчилэхгүй байх.
2. Хувь хүний ухамсараа дээшлүүлэх.
3. Тухайн ажилтан гэхээсээ илүүтэй үйлчилгээ авагч иргэнийг авлига өгөх гэдгийг болиулах түүнийг ил тод эсэргүүцэж байх хэрэгтэй.
4. Хяналт сайжруул.
Төрийн байгууллагын ажиллаж буй дээд дунд шатныудирдлагын ажилтнууд хандлага сайжруулах.
5. Ил тод шуурхай асуудлыг дор нь шийддэг байхад болно.
6. Хүн бөгөөд хүн чанартай байх гэж бодож байна.

Судалгааны нэгтгэл хийсэн: Ахлах төлөөлөгч Н.Шүрэн-Эрдэнэ